

# МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

## ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№19/496

ШУС, НУС

2018

### УРЛАГ, УТГА ЗОХИОЛЫН УУГАН НЭГ СЭТГҮҮЛИЙН ТУХАЙ

Л.Норовсүрэн\*

\*МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбарын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхмийн профессор, Шинжлэх ухааны доктор (Sc.D)

**Түлхүүр үг:** сэтгүүл, уран зохиол, уншигчид, шоглол, дэлхий, суралцах, шүүмжлэл, соёл боловсрол, тогтоол, зохиолч, тусгаар тогтнол, жүжиг, театр, сонин хэвлэл.

Гучаад оны Монголын хувьсгалт хэвлэлийн дотор утга зохиол, урлагийн сэтгүүлүүд том байр эзэлж байв. «Монгол ардын үндэсний соёлын зам» хэмээх урлаг, утга зохиолын ууган нэг сэтгүүлийн тухай ярихын өмнө 1929 онд «Уран үгсийн чуулган»-аар гараагаа эхэлсэн уран зохиол, урлагийн зарим тогтмол хэвлэл, тухайлбал 1929 оны сүүлчээр гарсан «Улаан туяа», 1932 онд гарсан «Хувьсгалын уран зохиол» зэрэг сэтгүүлийн талаар цухас боловч дурьдах нь зүйтэй. Учир нь 1934 онд гарсан «Монгол ардын үндэсний соёлын зам» сэтгүүл бол тэдгээрийн агуулга, хэлбэрийг шинэ шатанд гаргаж, шинэ Монголын уран зохиол, урлагийг хөгжүүлэх хэрэгт үнэтэй хувь нэмэр оруулсан юм.

Монголын хувьсгалт хэвлэлийн нийтлэлд уран сайхны арга барил нэвтрүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн буурьтай хэвлэлийн нэг нь «Монгол ардын үндэсний соёлын зам» сэтгүүл байлаа. Уг сэтгүүл БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс 1934 оны 1 дүгээр

сард Ардыг Гэгээрүүлэх Яамны Сайд Баттөмөрийн илтгэлийг авч хэлэлцээд «Үндэсний оюутан сэхээтэн нарын идэвх сонирхлыг татсан уран зохиол, уран сайхны болон нийгмийн зурагт сэтгүүл сар тутам гаргаж, тус улсын тусгаар тогтносон хувьсгалт төрийн бодлогод нийцүүлэн, өөрийн үндэсний соёлыг хөгжүүлэх» заалтын дагуу 1934 оноос эхлэн хэвлэгджээ.

Сэтгүүл анхныхаа дугаарт: «Бид түүхээ нэхэн санаваас, дэлхийг донсолгож, хүн төрөлхтний түүхэнд баатар эр зоригоор баллагдашгүй үлдсэн боловч дараа нь Манж, Хятадын арга мэхэнд автаж, буддын шашны бүдэг мананд төөрөлдсөн. Бароны гар хөлд нухлагдан түмэн гашуун, мянган зүдгүүрийг хүлээж, үндэс язгуур баллагдан сөнөхөд хүрч ирсэн боловч уурсан бухимдсан монголчууд умардаас гийгүүлсэн улаан гэрлийн дундаас өөрийн түүх бүхий баатар сүрийг нэгтгэн гаргаж, ард нийтийн сэтгэл хүчийг нэгтгэн, нөхөр Сүхбаатарын удирдлагын дор улаан Монголын улаан тугийг хөдөлгөж, сүрийг бадраалаа. Удамтай баатар нарыг залган илрүүлж, дорно дотор ганцаар хувьсгалт засгийг байгуулан, үндэсний тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг олж зохиосноор, бүгд одоо арав хориод

жилийн дотор ард нийтээр өөрийн газар шороондоо эзэн болжээ.

Соёл боловсролыг өргөжүүлэхийн тулд бүхий л ажил хэргийг гүйцэлдүүлэн дайсны зүг тэмцлийг хурцатган, нөхрийн зүг холбоог бэхжүүлэн, дотоодод бат хүчийг олж чадсан бөгөөд эхнээс өрнүүлсэн үндэсний хувьсгалын тэмцлээр олж тогтоосон онцгой байдлыг өрнүүлэх боллоо.

**А**рд олны үндэсний соёл боловсролыг дээшлүүлэн, нийт ардын идэвхийг төрүүлэхийн тулд ард нийтийг аливаа эрдэм ухаанд сургаж, боловсруулах, гэгээрүүлэхэд нэн тэргүүн сурталчилгаанд тулгуурлаж зааварлах учир бидний олныг удирдах засгийн газраас нийтийг бичиг үсэгт сургах, элдэв эрдэмд боловсруулах олон зүйлийн арга хэмжээг тогтоол гаргаж явуулан буйгийн дотор үндэсний соёл боловсролыг хувьсгалын чанартайгаар хөгжүүлэх явдлыг онц чухалчилсаар ирсэн ба нэн ялангуяа, саяхан Ардын Сайд нарын Зөвлөлөөс тогтоосон нэг тоот тогтоол болбол үндэсний соёл боловсролыг бүрэн хөгжүүлэх зорилт шаардлагыг улам чухалчлан даалгасны дээр энэ зорилт шаардлагын тухайн замыг заах тусгай сэтгүүлийг нийтлэхээр тогтоосон билээ. Иймийн тул Ардыг Гэгээрүүлэх Яамнаас энэхүү «Монгол ардын үндэсний соёлын зам» хэмээх сэтгүүлийг шинэ тутмаар тогтмол хугацаанд хэвлэн гаргаж, нийт ардын уншиж танилцахад бэлтгэх, дээр дурьдсан үндсэн бодлого ба тогтоолыг биелүүлэх улс төрийн үүргийг хүлээж, зорилтыг тавилаа» гээд, тус сэтгүүлийн зорилтыг тодорхойлсон байна. Үүнд:

1. Тус улсын үндэсний тусгаар тогтнол, хувьсгалт засаг төрийг гадаад дотоодын дайснаас батлан хамгаалж, эзэрхэг түрэмгий ба феодалыг эсэргүүцэх, хувьсгалыг өрнүүлэх явдал ард нийтийн анхаарлыг татаж, шинэ бат хүч болгон хувьсгалт засгийг өргөжүүлэн хүрээлүүлж батлахыг зоримой.
2. Тус улсын эдийн засгийн үндэс болох нэгдлийн мал аж ахуйг хөгжүүлэн бататгаж, ард нийтийн хувь хувийн аж амьжиргааг баялаг боловсон болгохын тул засгаас гаргаж буй бүх хууль, дүрэм, заавар, тогтоол тэргүүтнийг улмаар биелүүлэн гүйцэтгэх, таниулан мэдүүлэх явдлыг чухал болгохыг зоримой.
3. Үндэсний соёл боловсролыг хөгжүүлэн, үндэстнийг бататгах тухай засгаас явуулж буй хэрэг ажил ба бодлого зорилтыг хэрэг дээр болгон бэлтгэхийн тул ард нийтийн анхаарлыг татах аргуудыг чухалчилж тавина.
4. Дээрх гурван үндсэн зорилтыг биелүүлэхдээ тус сэтгүүл нь үндэсний соёл боловсролын хамгийн манлай, онц нарийн зэвсэг болох үндэсний уран сайхан хэмээх уран зохиол, шүлэг найраглал ба дуу хөгжим, радио, эгшиг өгүүлэлт хайрцаг гэх мэт зүйлийг таниулах, үндэсний жүжгийг явуулах, тэдгээрийн гайхамшигт уран сайхны зүйл, мөн хачин сор шагай, шатар, уралдах, барилдах зэргийг засан хөгжүүлэх ажлыг бүрэн боловсруулах аргыг гол болгон хэрэгжүүлж гүйцэтгэх явдлыг өөрийн зорилт үүрэг хэмээн үзэх бөгөөд үндэсний соёлын замыг нэгтгүүлэн чадах уран сайхны бүрэн чуулган болсон ард нийтийн хүслийг өрнүүлж, хувьсгалын суртал, соёлыг нэвтрүүлэх зорилтыг тавьсан сэтгүүл болно хэмээн хатуу зоримой.

Ийнхүү тулд дээр тодорхойлсон улс төрийн үндсэн бодлого ба засгийн чухалчилж шаардсан зүйлс хийгээд тус сэтгүүлийн хүлээх үүрэг, гүйцэтгэх зорилго ийм болохыг олон нийт ардаас сонирхон уншиж, ухварлан таниж, хүсэн шүүмжлэх саналаа тусламж үзүүлэн гаргаж явуулахыг гүн найдах бөгөөд, үндэсний эрдэмтэн, оюутан нөхөд ба уран сайхны авьяастан нөхдөөс энэхүү сэтгүүлийг хүрээлэн тойрч, эдгээртэй холбоотой зүйлийг өргөнөөр засан ирүүлж байх, засгийн ба ардын өмнө өөрсдийн хүлээсэн үүргийг гүйцэтгэн туслалцах буй заа хэмээн шууд итгэн найдаж байна. Залуу гавшгай оюутан нар, ардын үндэсний соёлын замыг нийтгэж, үндэсний уран сайхныг хөгжүүлэх хэрэгт тэргүүн мөрөнд зогсохоос бүү хожимдогтун. «Тус сэтгүүлийг эрхлэгчид нар» гэжээ.

«Монгол ардын үндэсний соёлын зам» сэтгүүлийн дэвшүүлсэн дээрх зорилтуудыг харахад уг сэтгүүл улс орны эдийн засгийг хөгжүүлэх, ард түмний аж байдлыг сайжруулах, соёл урлагийг хөгжүүлэх их үйлсэд утга зохиол, урлагийн бүтээлээр нөлөөлөхийг зорьж байсан нь ил байна» хэмээн судлаачид дүгнэсэн байдаг. Энэ сэтгүүл явцын дундаас буюу 1937 оны сүүлчээс нэрээ ялимгүй өөрчилж «Монгол ардын хувьсгалт соёлын зам» гэгдэх болсон нь 1937 оны хэлмэгдүүлэлт болон улс төрийн нөхцөл уялдан «үндэсний» хэмээх үгээс зайлсхийж, улам бүр «хувьсгалч» шинж чанартай болсныг харуулдаг. Тус сэтгүүл дотроо «Улс төр», «Уран зохиол», «Урлаг», «Шүүмжлэл» гэсэн хэд хэдэн ангитай байв.

«Улс төрийн анги»-д нийгэм улс төрийн байдал, цаг үеийн чухал асуудлуудыг хөндсөн тэргүүн, дагавар

өгүүллүүд дугаар бүрт нийтлэгдэж байв. «Уран сайхны ажилд анхаармой», «Үргэлж биелүүлэгтүн», «Аврагч этгээд үгүй гэж үү» гэх мэт олон өгүүлэл энэ ангид нийтлэгдэж байв. Мөн засгийн газраас гаргасан хууль, тогтоол, шийдвэр, дүрэм зэргийг энэ ангид байнга нийтэлдэг байжээ. Тухайлбал: Ардыг гэгээрүүлэх яамны сайд Баттөмөрөөс 1934 оны 1 дүгээр сарын 2-ны өдөр Сайд нарын Зөвлөлд «Үндэсний соёл боловсролыг хөгжүүлэх тухай» илтгэсэн илтгэл, «Жүжигчдийн тоглохдоо журамлах анхны хууль» зэрэг материалын зэрэгцээ «Монголын хувьсгалт хэвлэлийн агуу амжилттай арван таван жилийн ой мандтугай», «Ардын хоршоо байгуулагдсаны арван таван жилийн ойд», «Ардын ёсны шүүн таслах газрыг байгуулж, хувьсгалт хууль цаазыг тогтоосон 10 жилийн ойд», «Улсын төв театрын таван жилийн ойн баярт зориулсан түүний хөгжлийг товчлон зохиосон сонин зохиолоос товчилсон нь» гэх мэт аливаа ойд зориулсан олон өгүүлэл хэвлэгддэг байжээ.

Эдгээр өгүүлэлд уг байгууллага, газрын үүссэн түүх, өнөөгийн үйл ажиллагаа, ололт амжилт, ард нийтэд хүргэсэн ач тус, үр дүн зэргийг тод томруун харуулсан байна. Бас шинээр үйлдвэр байгуулагдсан хийгээд монгол мөнгөний тухай «Таван лан мөнгө», ард түмний аж байдал, амьдрал ямар байгаа талаар «Зовлонт ард Занданы үг» зэрэг мэдээ, өгүүлэл гаргаж, Зөвлөлт Холбоот Улс, Октябрийн хувьсгалын тухай болон Монголын хувьсгалд хүргэсэн Лениний ач тусыг өгүүлж байлаа. «Монгол ардын үндэсний соёлын зам» сэтгүүл бүтэн дугаараа улс нийтийн чанартай томоохон үйл явдалд зориулж,

сэдэвчилсэн байдлаар ч гарах тохиолдол байсан юм.

«Уран зохиолын анги»-д «Уран сайхан» гэсэн тусгай булантай байлаа. Улс орон феодалын үеийн байдлаас ангижирч, социализмын замаар хөгжих зорилт тавин тэмцэж байгаа үед уран зохиол тэр тэмцлийн гол зэвсэг байх ёстой гэж үздэг байжээ. Монголын хувьсгалт хэвлэлийн нийтлэл гучаад онд урьдаас баяжиж, бичлэгийн шинэ төрөл, зүйлүүд гарч, орчин үеэ хурц тусгасан өгүүллэг, найраглал, тэмдэглэл, шог найруулал зэрэг зүйлүүд цоо шинээр үүсэн буй болж байсныг энэ сэтгүүлийн нийтлэлээс харж болно. Түүний зэрэгцээгээр уншигчид нөлөөлөх чадвар сул, хий чамирхаж уран үгээр хөөцөлдсөн, эсвэл зохиогчийн хэлний болон ерөнхий мэдлэг дутсан гэмээр нийтлэл ч хааяа тааралддаг. Энэ нь сонин хэвлэлийн тоо огцом өссөн үед редакциуд материалаар дутагдаж, идэвхтний захидал мэдээлэлд тавих шаардлага зарим талаар суларсантай холбоотой байж болно.

**Д**.Нацагдоржийн «Үзэгдээгүй юм», Д.Цэвэгмидийн «Хоньчин Найдан», «Бургаст голын Болд, Самбуу хоёр», Д.Наваан-Юндэнгийн «Гөрөөчин ах охин дүүдээ», «Тал дээрх ганц гэр», С.Буяннэмэхийн «Аргалт уулын бялзуухай», Д.Содномдоржийн «Урианхай Балжинням», М.Ядамсүрэнгийн «Залуу хос», «Гурван хүүхэн», «Анхаарч биширсэн чавганц, адаран хорссон лам хоёрын үнэн байдал», Н.Цэенжавын «Эрдэнэцэцэг охины зам дээр» зэрэг манай шинэ үеийн уран зохиолын дээжис энэ сэтгүүлд хэвлэгдэж байв.

Тус сэтгүүлд манай шинэ үеийн уран зохиолыг үндэслэгчид болох Д.Нацагдорж, Ц.Дамдинсүрэн, С.Буяннэмэх нарын томоохон сэтгүүлч,

зохиолчдоос гадна Наваан, Ишдорж, Дагвадорж, Галдан, Сэнгэдорж, Цэрэндорж нарын зэрэг хүмүүс ажиллаж байжээ. Д.Нацагдоржийн нийтлэл нь феодалын нийгмийн хоцрогдол, түүний бүдүүлэг ёс суртахууныг зүйл зүйлээр шүүмжилж, ардын хувьсгалт байгууллын өөрчлөлт шинэчлэлт, ололт амжилтыг сурталчлахад чиглэгдэж байв. Түүний нийтлэл уран дүрслэлээр баялаг, бодит үнэнд тулгуурласан, цаг үеийг гярхай тусгаснаараа онцлог байв. Хувьсгалаар сэргэн мандсан нутаг усныхаа байгал дэлхийн гоо үзэсгэлэн, эх орныхоо орчин үе, ирээдүйн хувь заяаны тухай гүн ухааны сэтгэлгээ нэвтэрхий, сэтгэл зүрхнээсээ догдлон бичсэн «Миний нутаг» шүлэг нь анх удаа тус сэтгүүлийн хуудсанд нийтлэгдэж байв. Түүнчлэн С.Буяннэмэх «Монгол ардын үндэсний соёлын зам» сэтгүүлийг эрхлэн гаргагчдын нэг бөгөөд уг сэтгүүлд ардын хувьсгалын ялалт, ардын журамт цэргийн тулалдааныг амжилттай зохион байгуулахад их жанжин Д.Сүхбаатарын гавьяаг тод томруун дүрсэлсэн олон нийтлэл гаргажээ. Бас улс орны амьдралд холбогдох нийгмийн шинжтэй томоохон асуудлуудыг хөндсөн өгүүлэл, шүүмж олныг бичиж байв.

Мөн сэтгүүлд М.Горькийн «Эх» роман, «Салхич шувууны дуун» зэрэг Оросын сонгодог зохиолуудыг орчуулан нийтэлж байсан нь тун сайшаалтай хэрэг байв. Энэ нь Монголын ард түмнийг дэлхийн уран зохиол, урлагаар дамжуулан гэгээрүүлэх нэг чухал алхам болсон байна.

Тус сэтгүүл уран зохиолын судлал шүүмжлэлд зориулсан тусгай булантай байв. Гучаад онд манай уран зохиолын шүүмж судлалын эхлэл тавигдсан билээ. Зохиолын шүүмж гэдэг нь зохиолыг зөвхөн муушаан

өөлөхийн нэр биш, улам сайжруулах, зохиогчийг хойшид сайн зохиолч болгохын тулд бурууг нь засах, үндэсний урлаг, уран зохиолыг хөгжүүлэн мандуулахад чиглэгддэг гэж тус сэтгүүл бичиж байв.

Энэ сэтгүүлд хуучин бичгийн хэлний найруулгыг эрхэмлэн, түүний дэг журмыг бат сахиж, үлэмж тал өгдөг Б.Ринчений «Орчуулгын хэлний тухай», монгол үгсийн санг феодалын болоод ардын хэл гэж хиймлээр хэсэг ангид хуваан эндүүрч байсан хэлний багш Жүрмэдийн «Уран сайхны уран шүүмжлэл» зэрэг бүтээл энэ буланд гарч байлаа. Мөн сонин хэвлэлийн хэл найруулгыг сайжруулах, нийтлэлийн арга барилыг боловсронгуй болгох, идэвхтэн бичигчдийг дэмжих талаар их зүйл хийсэн С.Буяннэмэхийн уран зохиолын судлал шүүмжлэлтэй холбоотой зүйлүүд гарч байв. Жишээлбэл: «Далд утгатай шүлэг», «Далд сэтгэл ойлгохуй ба түүний тухай хэдэн үг» зэрэг шүүмж судлалын өгүүллийг нэрлэж болно. Энэ буланд гарч байсан шүүмжүүд нь манай шинэ үеийн уран зохиол, урлагийг хөгжүүлэх, залуу зохиолч, идэвхтэн бичигчдийг олноор төрүүлэх, сайн зохиол бүтээл олшроход ихээхэн нөлөө үзүүлсэн байна. Мөн зохиолчид ард түмний шинэ хувьсгалт ахуй, төрж өссөн нутаг ус, газар орноо магтан бичиж буйг сайшаан дэмжиж байжээ. Жишээ нь: Д.Нацагдоржийн «Миний нутаг», Г.Сэр-Одын «Дөмөн», Д.Наваан-Юндэнгийн «Баян монгол», «Үхэрчин хүү», Д.Ичинхорлоогийн «Хоньчин хөвгүүн» гэх мэт зохиолуудыг нийтэлж байв.

Монголын шинэ үеийн уран зохиолын хөгжилд чухал үүрэг гүйцэтгэсэн Ч.Дашнямын шүүмж, шинжлэх ухааны элдэв хялбарчилсан өгүүлэл энэ сэтгүүлд олон хэвлэгдэж байв.

«Монгол ардын үндэсний соёлын зам» уран зохиол, урлагийн сэтгүүл болох хувьдаа ардын урлаг, дуу хөгжим, театрын урлагт ихээхэн анхаарал тавьж байв.

**М**.Дугаржавын бичсэн «Үндэсний дуу хөгжмийг хэрхэн мандуулах вэ?» хэмээх өгүүлэлд хуур, ятга ба уянгат сайхан дууны уламжлалтай манай оронд сүүлийн үед яруу сайхан дуу хөгжим зохиогдохгүй байгааг шүүмжилж: «Манай нөхдөөс бичсэн дууны үг бидэнд элбэг олдоно. Харин тэр үгний хүнд хөнгөн, утга чанар, учир байдалд тохируулан шинэ ая зохиох явдал чухал байна» гэжээ. Мөн Ө.Чимидийн «Сайн морины тухай түүхээс Монголын үндэсний хөгжим зохиогдсон тухай», М.Ядамсүрэнгийн «Үндэсний бүжгүүд гайхамшигтайгаар зохиогдов» гэх зэрэг ардын үндэсний урлагтай холбоотой олон өгүүлэл, шүүмж, асуудал дэвшүүлсэн өгүүлэл, түүх домог гарч байв. «Монгол ардын үндэсний соёлын зам» сэтгүүлд театрын урлагийн тухай бичихдээ театр бол хүмүүсийг зөвхөн саатуулж, зугаацуулах газар биш, ард түмэндээ уран сайхнаар үйлчилж, гэгээрүүлж соёлжуулах, намын бодлогыг сурталчлах чухал газар гэдгийг онцлон тэмдэглэсэн байна. Сэтгүүлд театрын дотоод үйл ажиллагаа, түүний гол цөм болсон жүжигчдийн ажил байдлыг харуулсан сурвалжлага, өгүүлэл, ярилцлага нийтлэгдэж байлаа. Жишээ нь тус улсын дотор Үндэсний театрын урлаг хэрхэн эмхлэгдэн зохион байгуулагдаж, хэлбэрэлтгүй хөгжиж байгааг харуулж, театрын дууч, хөгжимчин, жүжигчдийн сэтгэгдлийг нийтэлснийг уншигчид их сонирхдог байжээ. Тус сэтгүүл ард түмэнд соёл урлаг, боловсролыг түгээхэд чухал үүрэг гүйцэтгэж байсан клуб, улаан

булангийн талаар ч нийтэлж байсан байна. Тухайлбал: «Үлгэр жишээ клубийн байдлаас» гэдэг өгүүлэлд: «Амгаланбаатар хотод төрсөн нөхөр Сүхбаатарын нэрийн дор байгуулагдсан ардын үлгэр жишээ клуб нь ардыг гэгээрүүлэх зам дахь саадыг арилгаж, өөрийн бүхий л ажлаар орон нутаг, аймаг, хотын олон клубүүдэд үлгэр жишээг үзүүлж, түүнчлэн ард олны дотор соёл боловсрол, уран сайхны ажлыг дээшлүүлэх үндсэн зорилтыг тавиад ажиллаж байна. Учир иймээс тус клуб нь анх байгуулагдахдаа эл үүргийг хатуу замын өмнө хүлээж гүйцээсэн ажлаас дурьдвал: Театрын бүлгэмд жүжигчид 16, сурагч 3, Үндэсний дуу ба хөгжмийн бүлгэмд хөгжимчин, дуучин 13, сурагч 5, Уран зохиол, биеийн тамирын бүлгэмд сурагч 18, Үндэсний бичиг үсэг сурах бүлгэмд сурагч 27, бүгд 6 төрлийн бүлгэмтэй болж, өөрийн төлөвлөгөө бүхий ажилд ард түмнээс хүрээлэн дуурайж, тус бүрдээ ноогдсон ажилдаа анхааралтай бөгөөд халамжтайгаар оролцон хөгжүүлсний улмаас хэвлэн нийтлэгдсэн “Харанхуй засаг”, “Шөнийн буг”, “Би биш”, “Цоожтой хаалганы цаад талд” зэрэг жүжгийг тус бүр дөрвөөс доошгүй удаа гаргаж чадсан ба шинэ том зохиол 3, жүжиг үзэгдэл 6-г өөрсдөө зохиож, сургуулийг боловсруулан үйлдэж, ард олны дотор ба улаан цэргийн дунд гаргаж сонирхуулсан хийгээд радиогоор дуу хөгжим 6 удаа, бичиг үсгийг 7 хоногт 4 удаа заах зэргээр сургуулилан ажиллуулсан ба биеийн тамир, бичиг үсэг нь тус улсын тусгаар тогтнол хийгээд эзэрхэг түрэмгий ба феодалыг эсэргүүцсэн хувьсгалыг туйлд нь хүргэх хэргийг ойлгуулсан...» гэх мэтээр бахархан өгүүлжээ. Тус сэтгүүл ингэж амжилттай сайн ажиллаж байгаа газруудын арга

туршлага, ололт амжилтыг олон түмэнд сурталчилсан нь бусдад үлгэр дуурайл болох олон талын ач холбогдолтой байв.

«Монгол ардын үндэсний соёлын зам» сэтгүүл манай анхны өнгөт зурагтай сэтгүүлүүдийн нэг бөгөөд нүүрний дизайн, зураг чимэглэл, өнгө үзэмжид ихээхэн анхаарч байсан нь ажиглагдаг. Энэ сэтгүүлд уран зохиолын зүйлийг уншигчдын ухааж мэдэхэд хялбар дөхөм, товч тодорхой хэлбэрээр нийтэлж, зураасан болон гэрэл зургийг ихээхэн ашиглаж байв. Ялангуяа хуучин нийгмийн байдал, хар шар феодалууд, тэдний арчаагүй, гутамшигтай дүр төрхийг гар зургаар шоглон гаргадаг байсан бөгөөд энэ нь ард нийтийн сэтгэлд нөлөөлөхүйц ач холбогдолтой байв.

Тус сэтгүүл анхны дугаартаа: «Сэтгүүлд хэвлэгдсэн зургуудын олонх нь шинжлэх ухааны хүрээлэн ба хувьсгалын музейн зургийн газраас авсан зургууд бөгөөд Улсын хэвлэлийн хорооноос 1500 хувийг хэвлэн нийтлэв» гэжээ. Ер нь энэ сэтгүүлд зураг дүрслэлгүй нийтлэл бараг гардаггүй байсан нь сонин бөгөөд зураг, дүрслэлийг чадамгай ашигласан нь олонтаа тааралдана. Тухайлбал: Д.Нацагдоржийн «Миний нутаг» шүлгийг нийтлэхдээ арын дэлгэмэл нүүрэнд нь Монгол улсын газрын зургийг зурж, түүнийгээ тойруулан Монголын говь, хангай болон Хөвсгөл далай, Туул гол, Орхон гол, говийн заг, монгол хот айлын фото зургийг маш тодорхой тайлбартайгаар тавьжээ. Үүнийг харж, шүлгийг уншсан монгол хүний сэтгэл хөдөлж, үзэсгэлэнт сайхан эх орноороо бахархах сэтгэл төрүүлэхүйц болсон байна.

Сэтгүүлд гарсан бас нэг шинэлэг зүйл нь «Ардын хоршооны 15 жилийн ойд» гэсэн сэдэвчилсэн дугаарт нийтлэгдсэн гар зураг, бүдүүвч юм. Түүнд, манай улсад хоршоо анх үүссэнээс хойших 15 жилийн дотор ямар амжилтанд хүрч, Монгол нутгийг хэрхэн хамарч чадсан байдлыг ойлгомжтой зурж үзүүлжээ.

«Жүжигчдийн тоглохдоо журамлах анхны хууль» гэдэг бичлэгт хамгийн олон гэрэл зураг орсон байна. Үүнээс жүжигчдийн болон Улсын төв театрт тавигдаж байсан жүжгүүдийн хэсгийг харуулсан зургууд илүү сонирхолтой болжээ. Сэтгүүл өнгө үзэмжийг сайжруулах зорилгоор үсгээ тод өнгөөр өгч, дэвсгэрээс нь ялгагдаж байсан нь хүмүүсийн харааг булаах, сэтгэл зүйд нөлөөлөх ач холбогдолтой байжээ. Энэ нь уран зохиол, урлаг соёлын тухай бичдэг тус сэтгүүлийн нийтлэлийн

бодлоготой уялдсан оновчтой шийдэл байв. Нүүрүүдийн бичвэрийн харьцааг тохируулж, гэрэл зургийг зөв байрлуулсан нь уншигчийн ойлгоход сайн нөлөөтэй байжээ. Дашрамд сонирхуулахад «Монголын ардын үндэсний соёлын зам» сэтгүүл өөрийн захиалгын рекламьг дугаар бүртээ нийтэлдэг байв.

Ер нь тус сэтгүүлд гарч байсан нийтлэлүүдийг ажиглахад хүмүүсийн бодол санаа, шүүмжлэл дүгнэлт зэргийг нэлээд сайн тусгасан байдаг нь сэтгүүлийн зөвлөлөөс уншигч, сэтгүүл

хоёрын эргэх холбоонд гойд анхаардаг байсныг илтгэж байна.

«Монгол ардын үндэсний соёлын зам» сэтгүүл нь улс орны эдийн засгийг хөгжүүлэх, ард түмний аж байдлыг сайжруулах, хувьсгалт засгийг бататгах, соёл урлаг, боловсролыг хөгжүүлэх их үйлсэд утга зохиол, урлагийн бүтээлээр нөлөөлөх зорилгоор 1934-1940 оныг хүртэл нийт 30 гаруй дугаар гаргахдаа шинэ үеийн утга зохиолын хөгжилтөд чухал үүрэг гүйцэтгэсэн сэтгүүл юм. Сэтгүүл,

тухайн үед харанхуй бүдүүлэг байдлаас бүрэн салж чадаагүй байсан хүн ардыг гэгээрүүлж боловсруулах, эрдэм мэдлэгийг дэлгэрүүлэхэд багагүй хувь нэмэр оруулсан бөгөөд Монголын театрын урлаг, утга зохиолын судалгаа, шүүмжлэлийн хөгжилд ч чухал үүрэгтэй байжээ. Мөн урлаг, уран зохиолын бие даасан тусгай хэвлэл цаашид бүрэлдэн хөгжихөд чухал түлхэц болсон байна.

«Монгол ардын үндэсний соёлын зам» сэтгүүл тогтмол хэвлэлийн ач холбогдлыг ухуулсан, түүний нийтлэлийн чанарыг сайжруулж, хувьсгалын үйл хэрэгт туслахыг уриалсан зүйлийг байнга гаргадаг байв. Тухайлбал: ««Соёлын зам» би намын гишүүн бүхэнд нэгэн чухал зэвсэг шүү» гэсэн гарчигтай редакцийн өгүүллийг дурдаж болно. Энэ өгүүлэлд шинэ нийгэм байгуулах, хүн ардын соёл, боловсролыг ахиулахад хэвлэлийн үүрэг асар

«

**«Монгол ардын үндэсний соёлын зам» сэтгүүл нь улс орны эдийн засгийг хөгжүүлэх, ард түмний аж байдлыг сайжруулах, хувьсгалт засгийг бататгах, соёл урлаг, боловсролыг хөгжүүлэх их үйлсэд утга зохиол, урлагийн бүтээлээр нөлөөлөх зорилгоор 1934-1940 оныг хүртэл нийт 30 гаруй дугаар гаргахдаа шинэ үеийн утга зохиолын хөгжилтөд чухал үүрэг гүйцэтгэсэн сэтгүүл юм**

»

их болохыг сэтгүүл өөрөө ярьж байгаа маягаар илэрхийлсэн нь аливаа амьтан, эд юмсыг өгүүлэгч болгон бичдэг хуучин уламжлалыг ашигласны жишээ юм.

Түүнчлэн сонин сэтгүүл зэрэг олон нийтэд зориулсан мэдээллийн хэрэгсэл үр ашигтай байх чухал нөхцлийн нэг нь өөрийн хуудсыг аль болох олон ардын санаа бодол, шүүмжлэл өгүүллээр дүүргэж, хэвлэлийнхээ олон нийтийн үндсийг бэхжүүлэх явдал мөн гэсэн санааг сонирхолтой хэлбэрээр гаргасан байна. Тухайн үед шүүмжлэл, өөрийн шүүмжлэлийн тухай их ярьж, бичдэг байсны ул мөр энэ өгүүлэлд ч тодорхой туссан үзэгдэнэ. Эдгээрийн зэрэгцээ гэрч баримт багатай, хэт сүржигнэсэн, хий хоосон уриалж дуудсан бичлэгт нэлээд зай талбайгаа эзлүүлдэг байсан гучаад оны хэвлэлийн сул талыг ч тус сэтгүүлийн нийтлэлүүдээс харж болохоор байдаг.

**С**этгүүлийн 1936 оны №1-д Лу.Цэнд-Очирын нийтлүүлсэн «Ард түмэн ба хэвлэл» гэдэг шүлэглэлт нийтлэлд: «...Монгол ардын идэр хүү Сонин сэтгүүл уншиж сонсоод Мөхөшгүй баатрын зангилгыг Эрдмийн үсгээр шинжилж заагсад Монгол улсын шинэхэн хэвлэлийг Уянгын дуугаар хосолж дуулаад Өөрийн улсын тогтоол заавар Яруу үгсийн уран чуулганыг Өтгөн шингэн уянгын дуугаар Агаарын дундуур цацарган түгээж Үндсэн соёлын хурц тэмцэл Эрдмийн сумыг чиглэн заагч Үнэнч манай шинжлэхүй ухаан Бидний ардын ариун зам...» хэмээн бичсэн байна.

«Монгол ардын үндэсний соёлын зам» сэтгүүл ийнхүү хэвлэлийн сурталчилгааг идэвхтэй хийж байсан нь тухайн цаг үед ард олныг гэгээрүүлэхэд хэвлэл асар их үүрэг гүйцэтгэж

байсантай холбоотой юм. Дээрх хоёр нийтлэлийг шүлгийн хэлбэртэй бичсэн нь цээжилж тогтоогоод цааш цааш уншиж дэлгэрүүлэхэд дөхөмтэйг бодсон хэрэг байна.

«Монгол ардын үндэсний соёлын зам» сэтгүүлийнхэн 1921 оны үндэсний ардчилсан хувьсгалын 14 жилийн ойд зориулж хэд хэдэн томоохон нийтлэл гаргасны дотор М.Ядамсүрэнгийн бичсэн 1935 оны дугаарт нийтлэгдсэн «Үндэсний хувьсгалын арван жилийн ой ба үндэсний уран сайхан» гэдэг уран нийтлэл мөн «Арван дөрвөн жилийн ой ба бидний гүйцэтгэх ажил» гэсэн бичвэр, 1935 оны №8-д С.Буяннэмэхийн бичсэн «Европын дайны нэгэн өглөө» гэдэг нийтлэлийг дурдахгүй байхын аргагүй.

### Дүгнэлт

1. Монгол ардын үндэсний соёлын зам» сэтгүүлд манай шинэ үеийн уран зохиолыг үндэслэгчид ажиллаж, зохиол бүтээлээ нийтлүүлж байсан нь Монголын уран зохиол, урлагийн сор бүтээлүүдийг хуудсандаа хадгалсан түүхийн үнэт зүйл болоход нь нөлөөлжээ.
2. Тус сэтгүүлд дэлхий дахины болон Орос Зөвлөлтийн шилдэг зохиол бүтээлүүдийг төрөлх хэлээрээ орчуулан гаргаж, уншигчдын ухааныг тэлэх, мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор элдэв таавар, түргэн хэллэг, цэцэн мэргэн үгс, шатрын бодлого зэргийг нийтэлдэг байв.
3. “Монгол ардын үндэсний соёлын зам” сэтгүүл орчин үеэ хурц тусгасан өгүүллэг, найруулал, тэмдэглэл, шог найруулал зэрэг бичлэгийн цоо шинэ төрлүүдээр сэтгүүл зүйн туршлагыг баяжуулж, ард олны боловсрол хүмүүжлийг ахиулан, өрнүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж чадсан томоохон сэтгүүл байжээ.



4. Сэтгүүлийн хэл найруулга тааруу, зарим нийтлэл нь өнгөц сүржин байдалтай байсан бөгөөд сүүл хэрдээ нийтлэлийн чанар нь суларч, гарахгүй саатаж байжээ. Иймээс «Унтсан нэг сэтгүүлийн учир» гэсэн гарчигтайгаар өөр хэвлэлд шүүмжлэгдэж байсан ч удаатай ажээ.

#### **Ашигласан бүтээлийн жагсаалт**

1. Норовсүрэн Л. 2000. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. II боть. УБ.
2. Норовсүрэн Л. 2005. Монголын нийтлэл. II дэвтэр. УБ.
3. Норовсүрэн Л. 2004. Монголын сэтгүүл зүйн онол, түүхийн тулгуур асуудлууд. (ШУ-ны докторын дис-сертаци). УБ.
4. Дэлэг Г. 1972. Монголын хэвлэл. I дэвтэр. УБ.
5. Дашням А. 1962. Монголд хэвлэл үүсч хөгжсөн түүхээс. УБ.
6. Содномдаржаа Т. 1965. Монгол ард улсын ном хэвлэлийн хураангуй түүх. УБ.
7. 1964. Сонин хэвлэл, радиогийн сурвалжлагч идэвхтний хөдөлгөөнийг далайцтай өрнүүлэе. УБ.
8. “Монгол ардын үндэсний соёлын зам” сэтгүүлийн хураамжууд. 1934, 1935, 1936, 1937 оны хураамжууд.